



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/203

Бат-Өлзий сум

Мотоциклийн хөдөлгөөнийг
түр хугацаагаар хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.10, 59.4.21, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.1, 9.4.3 дахь заалт, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын нутаг дэвсгэрт цас орж халтиргаа гулгаа үүссэн тул замын хөдөлгөөнд оролцогчдын аюулгүй байдал, осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол, эрсдлийг багасгах, замын хөдөлгөөн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор сумын төвд 2022 оны 12 дугаар сарын 01-ээс 2023 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд мотоциклоор замын хөдөлгөөнд оролцохыг түр хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах, иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх анхааруулга, сэрэмжлүүлэгийг өгч, сурталчилах ажлыг цахим хуудас, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сум Цагдаагийн тасгийн дарга (цагдаагийн ахмад Д.Энх-Амгалан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С. АМГАЛАН

